Архинд донтох эмгэгийн үеийн сэтгэл гутрал, сэтгэл түгшилтэд алкуремон уламжлалт эмийн үзүүлэх нөлөөг судалсан нь

Б.Ундармаа[1], Ч.Чимэдрагчаа[2], Д.Оюунчимэг[3], Э.Минжмаа[3], С.Золжаргал[3], Б.Төртогтох[3], Г.Энхзаяа[3], Ц.Эрдэнэбулган[3], Н.Эрдэнэбат[4], Б.Шийрэв[3], Д.Ганбат[3], Д.Чулуунболор[3], Б.Дэжидмаа[2], Т.Халиунаа[2], Н.Оюунцэцэг[1]

[1]АШУҮИС, МАУОУС, Уламжлалт эмчилгээний тэнхим
[2]Уламжлалт Анагаах Ухаан Технологийн Хүрээлэн
[3]Нийслэлийн Аддиктологи, зан үйл, сэтгэл заслын төв
[4]Этүгэн Их Сургууль, Анагаах ухааны тэнхим
Цахим шуудан: undarmaa.bayar@mnums.edu.mn, Утас: 89118982

Түлхүүр үг:
Чаннадсэлши
Гамильтон
Цунгийн сорил
Архины донтолт
Уламжлалт эм

Товч утга:

Үндэслэл: Дэлхий дахинд 2 тэрбум гаруй хүн архи, согтууруулах ундааг хэрэглэдэг ба тэдний 80 гаруй сая нь архи, согтууруулах ундааны хэрэглээнээс үүдэлтэй эмгэгтэй гэж ДЭМБ мэдээлжээ. Монгол улсын хэмжээнд хийсэн судалгаагаар 2023 оны байдлаар архинд донтох эмгэг 1994 онтой харьцуулахад 30 дахин нэмэгдсэн бөгөөд архинд донтох эмгэгтэй хүмүүсийн 46.6% нь архаг ядаргаа, сэтгэл түгших, сэтгэл гутрал, органик бус нойрны эмгэгтэй байна. Монголын уламжлалт анагаах ухаанд архины өвчний үед хэрэглэж ирсэн “Чаннадсэлши буюу Архины өвчнийг арилгагч дөрөв” хэмээх жор бий бөгөөд уг жорын талаар сурвалж зохиолд архи эсвэл усаар даруулж ууваас архинд согтсон архи хүсдэг нэгэн согтуугийн хязгаараас магад сэрнэ хэмээн ёгт үгээр тэмдэглэсэн байдаг. УАУТХ-нд 2015-2017 онд хэрэгжсэн төслийн хүрээнд энэхүү жорын хими, технологи, фармакологийн судалгааг хийж гүйцэтгэсэн ба алкуремон шахмал эмийн эмнэлзүйн судалгааг хийж, эмчилгээний практикт нэвтрүүлэх шаардлагатай байгаа нь энэхүү судалгааны үндэслэл боллоо. **Зорилго:** Архинд донтох эмгэгийн үеийн сэтгэл гутрал, сэтгэл түгшилтийн үед Алкуремон уламжлалт эмийн үзүүлэх нөлөөг судлах. **Арга, аргачлал:** Судалгааг эмнэлзүйн туршилт судалгааны загвараар, дескриптив судалгааны аргаар Аддиктологи, зан үйл, сэтгэл заслын төвийг түшиглэн хийсэн. Архинд донтох эмгэг оношлогдсон (ICD-10, F10.1 F10.2), судалгаанд хамруулах шалгуурыг хангасан, судалгаанд хамрагдахыг зөвшөөрсөн, 45 хүнийг хамруулан, Алкуремон 0.5 гр шахмал эмийг 1 удаад 2 ширхгээр өглөө, оройд 30 хоногийн турш уулгаж, эмчилгээний өмнө сэтгэл засал эмчилгээнд хамруулав. **Үр дүн:** Судалгаанд хамрагдсан архинд донтох эмгэгтэй хүмүүсийг оношийн бүлгээр ангилахад ICD-10 F10.2 буюу Архины хараат байдлын хамшинж оноштой 53.3% (n=24), F10.1 буюу Архийг хортой үр дагавар өгөхүйц хэрэглэх оноштой 46.7% (n=21) байв. Архины хамаарлыг Мичиганы сорилоор үнэлэхэд, эмчилгээний өмнө архины хараат байдлын дундаж оноо 32.24±11.23 буюу архины хамаарлын III үед хамаарагдаж байсан бол эмчилгээний дараа 30.40±10.01 оноо болж буурсан нь (P=0.03 t=2.17) статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа. Сэтгэл гутралын түвшинг Цунгийн сорилоор үнэлэхэд эмчилгээний өмнө сэтгэл гутралын дундаж оноо 45.17±9.67 байсан бол эмчилгээний дараа 30.06±7.61 оноо болж статистик ач холбогдол бүхий ялгаатай буурсан (P=0.0001 t=7.97). Сэтгэл түгшилтийн зэргийг Гамильтоны сорилоор үнэлэхэд, эмчилгээний өмнө сэтгэл түгшилтийн дундаж оноо 23.62±13.72 буюу хүнд зэргийн сэтгэл түгшилттэй байсан бол эмчилгээний дараа 8.91±7.99 оноо буюу дунд зэргийн сэтгэл түгшилт болж буурсан нь (P=0.0001 t=7.19) статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа. Архинд донтох эмгэгтэй хүмүүсийн архины хэрэглээнд нөлөөлөх зарим хүчин зүйлсийн хамаарлыг Pearson’s test ашиглан үнэлж үзэхэд судалгаанд хамрагдсан хүмүүсийн архи хэрэглэсэн нас 21.06±5.66 жил, архи хэтрүүлэн уусан жил 9.13±5.32, архины хараат байдлыг үнэлэхэд 33.40±9.72 оноо, сэтгэл гутралын түвшин 45.03±9.92 оноо, сэтгэл түгшлийн зэрэг 23.83±12.03 оноо тус тус байлаа. **Дүгнэлт:** Алкуремон уламжлалт эм нь архинд донтох эмгэгийн үеийн сэтгэл гутрал, сэтгэл түгшилтийг бууруулах (P< 0.05) үр дүнтэй байна. Архины хараат байдал нь сэтгэл гутралын түвшинтэй (r=0.52), сэтгэл түгших эмгэгтэй эерэг, хүчтэй хамааралтай болох нь (r=0.57) тодорхойлогдлоо.

Үндэслэл: Өнөө үед 15 ба түүнээс дээш насны хүн амын 7% буюу 400 сая хүн архи согтууруулах ундааг хэрэглэж байна. Үүнээс 209 сая хүн буюу дэлхийн насанд хүрсэн хүн амын 3.7% нь архинд донтох эмгэгтэй байна.[1,2] Дэлхий нийтэд архины хэрэглээнээс үүдсэн эмгэг нийт өвчлөлийн 1.4% хувийг эзэлдэг бол Монголд 6.2%-иар их байна.[3] Архины хэрэглээ дэлхийд дунджаар 100.000 хүн амд 37 байгаа бол Монголд 100.000 хүн амд 123 байна. Монгол улсын хэмжээнд хийсэн судалгаагаар 2023 оны байдлаар архинд донтох эмгэг 1994 онтой харьцуулахад 30 дахин нэмэгдсэн бөгөөд нэг хүнд ногдох архи, дарс хэмжээ 46.9 литр байгаа нь 2018 оноос 8.9 литрээр ихэссэн үзүүлэлттэй байна. Архинд донтох эмгэгтэй хүмүүсийн 46.6% нь архаг ядаргаа, сэтгэл түгших, биеийн зовуурь шаналгаа, сэтгэл гутрал, органик бус нойрны эмгэгтэй байж, сэтгэл түгших эмгэгтэй хүмүүсийн 8.6% нь, сэтгэл гутрах эмгэгтэй хүмүүсийн 9.3% нь архинд донтох эмгэгтэй хавсран тохиолдож байгааг судалгаагаар тогтоогдсон байна.[4,5]

Сүүлийн жилүүдэд архинд донтох эмгэгийн үед хэрэглэх шинэ эмийн бэлдмэлийг эрж хайх судалгааны ажил эрчимжиж байна.[6] Архины хамааралтай болох эмгэгийн үед донтолтоос сэргийлэх, удаан хугацаанд тогтвортой эдгэрэлтэд хүрэх нь эмчилгээний гол зорилго бөгөөд архаг архидалтын үед олон эрхтэн системийг хамарсан эмгэг өөрчлөлтүүд явагддаг. Орчин үед архины донтох эмгэгийн үед дахилтаас сэргийлэх, дуршил бууруулах эмчилгээнд хэрэглэгдэж буй нийлэг эмийн бэлдмэлүүд нь эмд дасах, элэг гэмтээх, элэгний цочмог ба архаг үрэвсэлтэй үед хэрэглэхэд тохиромжгүй байдаг.

Монголын уламжлалт анагаах ухаанд архи, согтууруулах ундаа нь гашуун, амтлаг гошуун амттай, их халуун, хортой чанартай.[7-10] Үүнийг балгаж үлэмж ууваас хүний мөн чанарыг өөрчлөх, амь насанд хохирол учруулах тул түүний гэм хор их юм хэмээн эртний сурвалжид дурдахдаа архины өвчний үед хэрэглэж ирсэн "Чаннадсэлши буюу Архины өвчнийг арилгагч дөрөв" хэмээх жор бий бөгөөд уг жорыг архи эсвэл усаар даруулж ууваас архинд согтсон архи хүсдэг нэгэн согтуугийн хязгаарааас магад сэрнэ хэмээн ёгт үгээр тэмдэглэсэн байдаг.[11]

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнд 2015-2017 онд хэрэгжсэн төслийн хүрээнд Чаннадсэлши жорын хими, технологи, фармакологийн судалгааг хийж гүйцэтгэсэн ба биологийн идэвхт бодисыг нийлбэр байдлаар ялган архинд донтох эмгэг, архины шалтгаант элэгний цочмог архаг үрэвслийн үед хэрэглэх Алкуремон шахмал эмийг гарган аваад байна.[12] Тус эм нь этилийн спиртийн дуршлыг бууруулж, этилийн спиртийн нөлөөгөөр үүсэх айдас, түгшүүрийг намдаах, этилийн спиртийн цочмог, архаг хордлогын үед элэг хамгаалах үйлдэлтэй ба цусанд агуулагдах этилийн спиртийн хэмжээг бууруулах, АЛДГ ферментийн хэмжээг нэмэгдүүлэх нөлөөтэйг илрүүлсэн. Мөн Алкуремон шахмал эм нь хурц болон архаг хорон чанар багатай нь судалгаагаар тогтоогдсон байна.[7] Иймд Алкуремон шахмал эмийг архины шалтгаант элэгний үрэвслийн үед элэг хамгаалах, наркологийн практикт дуршил бууруулах зорилгоор хэрэглэх боломж, үндэслэл, эмнэлзүйн судалгааг явуулах, эмчилгээний практикт нэвтрүүлэх шаардлагатай байгаа нь уг судалгааг хийх үндэслэл боллоо.

Зорилго: Архинд донтох эмгэгийн үеийн сэтгэл гутрал, сэтгэл түгшилтийн үед Алкуремон уламжлалт эмийн үзүүлэх нөлөөг судлах

Арга, аргачлал: Судалгааг эмнэлзүйн туршилт судалгааны загвараар, дескриптив судалгааны аргаар Аддиктологи, зан үйл, сэтгэл заслын төвийг түшиглэн хийсэн. Архинд донтох эмгэг оношлогдсон (ICD-10, F10.1 F10.2), судалгаанд хамруулах шалгуурыг хангасан, судалгаанд хамрагдахыг зөвшөөрсөн, 45 хүнийг хамруулан, Алкуремон 0.5 гр шахмал эмийг 1 удаад 2 ширхгээр өглөө, оройд 30 хоногийн турш уулгаж, эмчилгээний өмнө сэтгэл засал эмчилгээнд хамруулав.

Асуумж судалгааг эмчилгээний өмнө, эмчилгээний дараа буюу 30 хоногийн дараа давтан үнэлсэн. Судалгаанд оролцогчдын архины хамаарлыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн 21 асуулт бүхий Мичиганы сорилоор үнэлэн үр дүнг тооцсон. Үнэлгээ: 0-5 оноо бол Архины хараат байдал илрээгүй, 5-7 оноо Архины хараат байдалтай байх магадлалтай, 7-15 оноо Архины хараат байдлын 1-р үе, 15-25 оноо Архины хараат байдлын 2-р үе, 25 ба түүнээс дээш оноо нь Архины хараат байдлын 3-р үе тус тус тодорхойлсон.[13]

Бид сэтгэл гутралын түвшинг үнэлэхдээ "Сэтгэл гутралын шалтгаан, түвшинг тодорхойлох Цунгийн сорил" асуумжаар үнэлсэн. Үнэлгээ: 25-49 оноо хэвийн сэтгэл гутрал үгүй, 50-59 оноо хөнгөн сэтгэл гутралтай, 60-69 оноо далд сэтгэл гутралтай, 70 ба түүнээс дээш- сэтгэл гутралтай гэж тооцсон. Харин сэтгэл түгшилтийн зэргийг үнэлэхдээ "Сэтгэл түгшилтийг тодорхойлох Гамильтоны сорил" асуумжаар үнэлж үр дүнг тооцсон. Үнэлгээ: 0-7 оноо Сэтгэл түгшил үгүй, 8-19 оноо Сэтгэл түгшилт байх магадлалтай, 20 ба түүнээс дээш- Сэтгэл түгшилтийн байдалтай гэж тус тус үзэв.

Статистик боловсруулалт: Судалгааны ажлын үр дүнгийн статистик боловсруулалтыг SPSS-21.0 программаар гүйцэтгэж, дунджийг 95 хувийн итгэх хязгаар, стандарт хазайлттайгаар тооцоолж, хугацааны дунджийн ялгааг Paired sample T-test ашиглан, хувьсагчдын хамаарлыг Pearson's test ашиглан үнэлсэн. Үнэн магадлалын шалгуур $p< 0.05$ үед судалж байгаа хувьсагч нь статистикийн үнэн магадлалтай ялгаа байна гэж үзсэн.

Ёс зүй: Эрүүл Мэндийн Яамны Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны 2023 оны 11-р сарын 13-ны өдрийн 23/066 тоот тогтоол, АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2024 оны 06 сарын 14-ний өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлж судалгааг эхлүүлэх ёс зүйн зөвшөөрөл (№2024/3-06) авсан.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан архинд донтох эмгэгтэй хүмүүсийг оношийн бүлгээр ангилахад ICD-10 F10.2 буюу Архины хараат байдлын хамшинж оноштой 53.3% (n=24), F10.1 буюу Архийг хортой үр дагавар

өгөхүйц хэрэглэх оноштой 46.7% (n=21) байв. Нас, хүйсний хувьд 30-68 насны нийт 45 хүн хамрагдсанаас эрэгтэй 37 (82.2%), эмэгтэй 8 (17.8%), дундаж нас нь 49.58±9.05 байна. Боловсролын хувьд 55.6% (n=25) нь бүрэн дунд, 44.4% (n=20) нь дээд боловсролтой байв. Хөдөлмөр эрхлэлтийг судалж үзэхэд судалгаанд хамрагдсан архинд донтох эмгэгтэй хүмүүсийн 28.9% (n=13) нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 26.7% (n=12) нь ажилчин, 20% (n=9) нь тэтгэвэрт, 11.1% (n=5) нь албан хаагч, 4.4% (n=4) группт, ажил хөдөлмөр эрхэлдэггүй, 2.2% (n=1) малчин хүмүүс эзэлж байна. Архинд донтох эмгэгтэй хүмүүсийн гэр бүлийн байдлыг судалж үзэхэд 77.8% (n=35) нь гэр бүлтэй, 13.3% (n=6) нь огт гэрлээгүй, 8.9% (n=4) нь хамтран амьдрагчтай амьдарч байна. Судалгаанаас харахад дийлэнх хувийг хууль ёсны гэр бүлтэй хүмүүс эзэлж байна. Архинд донтох эмгэгтэй хүмүүсийн 73.3% (n=33) нь тамхи татдаг, 26.7% (n=12) нь тамхи татдаггүй байлаа. Архи хэтрүүлэн хэрэглэж ирсэн хугацаа 1-25 жил, дундаж хугацаа нь 8.86±5.89 байв.

Архины хамаарлыг Мичиганы сорилоор үнэлэхэд, эмчилгээний өмнө судалгаанд оролцогчдын архины хараат байдлын дундаж оноо 32.24±11.23 буюу архины хамаарлын III үед хамаарагдаж байсан бол эмчилгээний дараа 30.40±10.01 оноо болж буурсан боловч (P=0.035 t=2.17) статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа. Сэтгэл гутралын түвшинг Цунгийн сорилоор үнэлэхэд эмчилгээний өмнө сэтгэл гутралын дундаж оноо 45.17±9.67 байсан бол эмчилгээний дараа 30.06±7.61 оноо болж статистик ач холбогдол бүхий ялгаатай буурсан нь (P=0.0001 t=7.97) Алкуремон уламжлалт эм архинд донтолтын үеийн сэтгэл гутралыг бууруулж байгааг харуулж байна. Сэтгэл түгшилтийн зэргийг Гамильтоны сорилоор үнэлэхэд, эмчилгээний өмнө сэтгэл түгшилтийн дундаж оноо 23.62±13.72 буюу хүнд зэргийн сэтгэл түгшилттэй байсан бол эмчилгээний дараа 8.91±7.99 оноо буюу дунд зэргийн сэтгэл түгшилт болж буурсан нь (P=0.0001 t=7.19) статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдагсдын сэтгэл гутрал болон, сэтгэл түгшилтийн зэргийг архины хамааралтай уялдуулан судалсан үр дүн

Үзүүлэлтүүд	Эмчилгээний өмнө	Эмчилгээний дараа	P утга
Архины хараат байдлын зэрэг	32.24±11.23	30.40±10.01	0.035
Сэтгэл гутралын түвшин	45.17±9.67	30.06±7.61	0.000
Сэтгэл түгшлийн түвшин	23.62±13.72	8.91±7.99	0.000

Архинд донтох эмгэгтэй хүмүүсийн архины хэрэглээнд нөлөөлөх зарим хүчин зүйлсийн хамаарлын байдлыг хамаарлыг Pearson's test ашиглан үнэллээ. Архи анх хэрэглэсэн насыг архи хэтрүүлэн уусан жилтэй хамааралтай эсэхийг үнэлж үзвэл сөрөг, сул хамааралтай (r=-0.01) P=0.94 байгаа нь архинд донтох эмгэг архийг анх ууссан хугацаанаас шалтгаалдаггүй болох нь тодорхойлогдож байна. Мөн архины хараат байдалтай сөрөг, сул хамааралтай (r=-0.25) P=0.08 болох нь тодорхойлогдлоо. Архи анх хэрэглэсэн нас сэтгэл гутрал, сэтгэл түгшлийн түвшинтэй сөрөг, сул хамааралтай (r=-0.15) P=0.30, (r=-0.06) P=0.67 байгаа нь архи анх хэрэглэсэн нас сэтгэл гутрал, түгшилтэнд нөлөөлдөггүй болохыг харуулж байна. Архи хэтрүүлэн уусан жил нь сэтгэл гутралтай сөрөг, дунд хамааралтай (r=-0.35) P=0.01, харин архины хараат байдал сэтгэл гутралын түвшинтэй эерэг, хүчтэй хамааралтай (r=0.52) P=0.0001, сэтгэл түгшлийн зэргэтэй эерэг, хүчтэй хамааралтай (r=0.57) P=0.0001 болохыг тодорхойллоо. Сэтгэл гутралтай хүмүүс нь сэтгэл түгших эмгэгтэй эерэг, хүчтэй хамааралтай (r=0.52) P=0.0001 нь статистик ач холбогдол бүхий ялгаатай байв. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Архинд донтох эмгэгтэй хүмүүсийн архины хэрэглээнд нөлөөлөх зарим хүчин зүйлстэй уялдуулан судалсан дүн

Үзүүлэлтүүд	Дундаж, стандарт хазайлт	1	2	3	4
1. Архи анх хэрэглэсэн нас	20.71±5.04	-			
2. Архи хэтрүүлэн уусан жил	8.86±5.89	-0.01	-		
3. Архины хараат байдал	32.23±11.23	-0.25	0.06	-	
4. Сэтгэл гутралын түвшин	45.17±9.62	-0.15	-0.35*	0.52**	-
5. Сэтгэл түгшлийн зэрэг	23.62±13.72	-0.06	0.00	0.57**	0.52**

Тайлбар: **=дунд хамааралтай, **=хүчтэй хамааралтай*

Хэлцэмж: Сүүлийн жилүүдэд архинд донтох эмгэг, архины бие махбодид үзүүлэх нөлөө болон архинаас шалтгаалсан эмгэгийн үед хэрэглэх шинэ эмийн бэлдмэлийг эрж хайх судалгааны ажил эрчимжиж байна. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын судалгаагаар дэлхий дахинд 2023 онд 703000 хүн амиа хорлож нас барсан бөгөөд голлох шалтгаан нь сэтгэл гутрал болохыг дурджээ. Харин амиа хорлох оролдлого хийсэн хүмүүсийн 95% нь нийгэм сэтгэл зүйн хувьд асуудалтай, цөөн хувь нь сэтгэцийн эмгэгтэй гэж үздэг бөгөөд тэдгээр эмгэгийн 40% нь сэтгэл хөдлөлийн эмгэг, 20% нь архины шалтгаант эмгэг эзэлж байна.[14,15] Архины хамааралтай болох эмгэгийн донтолтоос сэргийлэх, удаан хугацаанд тогтвортой эдгэрэлтэнд хүрэх нь эмчилгээний гол зорилго юм. Ж.Бат-Эрдэнэ нарын Алкуремон шахмал

эмийн фармакологийн судалгаагаар хурц, архаг хорон чанар багатай, туршилтын амьтанд үүсгэсэн архины шалтгаантай элэгний цочмог, архаг үрэвслийн эмгэг загварын үед туршилтын харханд архи, ус хоёрыг чөлөөт сонголтоор уулган дуршил үүсгэхэд уг жор нь этилийн спиртийн дуршлыг бууруулж, этилийн спиртийн нөлөөгөөр үүсэх айдас, түгшүүрийг намдаах, этилийн спиртийн цочмог, архаг хордлогын үед элэг хамгаалах үйлдэлтэй ба цусанд агуулагдах этилийн спиртийн хэмжээг бууруулах, АЛДГ ферментийн хэмжээг нэмэгдүүлэх нөлөөтэйг илрүүлсэн. Түүнчлэн харханд этанолоор үүсгэсэн архаг хордлогын эмгэгийн үед нейротрансмиттерийн өөрчлөлтийг тэнцвэржүүлэх, мэдрэлийн эс хамгаалах үйлдэлтэй болох нь тус тус тогтоогджээ.[4] Бидний судалгааны үр дүнд Алкуремон шахмал эмийн нөлөөгөөр сэтгэл гутралын түвшинг Цунгийн сорилоор үнэлэхэд эмчилгээний дараа 30.96±8.23 оноо болж статистик ач холбогдол бүхий ялгаатай буурсан төдийгүй сэтгэл түгшилтийн зэргийг Гамильтоны сорилоор үнэлэхэд, эмчилгээний сэтгэл түгшилт болж буурсан статистик ач холбогдол бүхий ялгаатай үр дүн тодорхойлогдсон нь эдгээр судлаачдын үр дүнтэй дүйж байна. Мөн бусад эрдэмдийн судалгаагаар Алкуремон шахмал эмийн найрлага дахь нохойн хошууны цэцэгт (Flora Rosa Acicularis) агуулагдах астрагалин, гиперозид зэрэг флавоноид нь туршилтын амьтанд үүсгэсэн оксидатив стрессийн үед эс хамгаалах үр дүн тодорхойлогдсон нь бидний судалгааны үр дүнтэй дүйж байна.[16]

Дүгнэлт: Алкуремон уламжлалт эм нь архинд донтох эмгэгийн үеийн сэтгэл гутрал, сэтгэл түгшилтийг бууруулах ($P< 0.05$) үр дүнтэй байна. Архины хараат байдал нь сэтгэл гутралын түвшинтэй ($r=0.52$), сэтгэл түгших эмгэгтэй эерэг, хүчтэй хамааралтай болох нь ($r=0.57$) тодорхойлогдлоо.

Талархал: Энэхүү судалгааг ШУТС-ийн санхүүжилтээр “Архинд донтох эмгэгийг эмчлэх нөлөөтэй алкуремон шахмал шинэ эмийн стандартчлал, эмнэлзүйн судалгаа” сэдэвт Эрүүл Мэндийн Яамны захиалгат төслөөр хийж гүйцэтгэсэн болно.

Ном зүй:

1. *Global status report on alcohol and health and treatment of substance use disorders. World Health Organization.2023*
2. *Tumur-Ochir G, Perenleisambuu E-U, Vanchindorj B, Lkhagvasuren N, Oka T, Lkhagvasuren B. Prevalence of alcohol dependence in Mongolia: A nationwide population-based, cross-sectional study. Neuroscience Research Notes. 2023;6(2):181.181-181.110.*
3. *Chimed-Ochir O, Delgermaa V, Takahashi K, et al. Mongolia health situation: based on the Global Burden of Disease Study 2019. BMC Public Health. 2022;22(1):5.*
4. *ЭМЯ. Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалт. Судалгааны тайлан. Улаанбаатар.2023.*
5. *Д.Чимэдцэрэн. Архины хордлоготой үйлчлүүлэгчдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим асуудалд. Улаанбаатар2018.*
6. *Л.Эрдэнэбаяр. Архинд донтох өвчин. Улаанбаатар 2009.*
7. *Тумбаа.Х. Анагаах Ухааны Дөрвөн Үндэс. Улаанбаатар1990.*
8. *Хүсэхүй. Идээ ундааны жинхэнэ товч Улаанбаатар2005.*
9. *П.Батхуяг СОБЦ. Монгол эмийн судлал. Улаанбаатар2009.*
10. *Ишбалжир. Дөрвөн рашаан Өвөрмонгол Ардын хэвлэлийн хороо 2007.*
11. *Бат-Эрдэнэ Ж. Туршилтын харханд этилийн спиртээр үүсгэсэн хордлогын үед Чаннадсэлши жор болон Алкуремон бэлдмэлийн үзүүлэх нөлөө [Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл]. Эрхэс хэвлэх үйлдвэр.*
12. *Б.Саранчимэг. Чаннадсэлши талх эмийн стандартчиллын асуудалд. Улаанбаатар АШУУИС; 2015.*
13. *Koohpayehzadeh J, Azami-Aghdash S, Derakhshani N, et al. Best practices in achieving universal health coverage: A scoping review. Medical Journal of the Islamic Republic of Iran. 2021;35.*
14. *Пагмадулам С. Тамирчдын стресс болон сэтгэл гутралын түвшнийг тодорхойлон, хамаарлыг судалсан үр дүн. Эрүүл мэндийн шинжлэх ухаан. 2024;20((1)77):85-89.*
15. *Gupta R, Srivastava D, Sahu M, Tiwari S, Ambasta RK, Kumar P. Artificial intelligence to deep learning: machine intelligence approach for drug discovery. Molecular diversity. 2021;25:1315-1360.*
16. *Knox J, Scodes J, Wall M, et al. Reduction in non-abstinent WHO drinking risk levels and depression/anxiety disorders: 3-year follow-up results in the US general population. Drug and alcohol dependence. 2019;197:228-235.*

Effect of alcuremon traditional medicine on Alcoholism-related depression and anxiety

Undarmaa B[1], Chimedragchaa Ch[2], Oyunchimeg D[3], Minjmaa E[3], Zoljargal S[3], Enkhzaya G[3], Turtogtokh B[3], Erdenebulgan Ts[3], Erdenebat N[4], Shiirev B[3], Ganbat D[3], Chuluunbolor D[3], Dejidmaa B[2], Khaliunaa T[2], Oyuntsetseg N[1]

[1]Department of Traditional Medicine, International School of Mongolian Medicine, MNUMS
[2]Institute of Traditional Medicine and Technology
[3]Center for Addictology, Behavioral, and Psychological Assistance of the Capital City
[4]Department of Basic Medical Education, Etugen University
E-mail: undarmaa.bayar@mnums.edu.mn, Tel: +976-89118982

Background: According to WHO, over 2 billion people worldwide consume alcohol, with more than 80 million suffering from alcohol consumption-related disorders. A nationwide study conducted in Mongolia found that, as of 2023, alcohol dependence had increased 30-fold compared to 1994. Additionally, 46.6% of individuals diagnosed with chronic alcoholism experience chronic fatigue, anxiety, depression, and nonorganic sleep disorders. In recent years, there has been an increased focus on research into new medications for alcohol dependence. Synthetic medications commonly used to prevent relapse and reduce alcohol appetite in alcohol dependence may not be effective in cases where tolerance to the medication, liver damage, or acute and chronic hepatitis are present. In traditional Mongolian medicine, there is a prescription known as "Channadselshi - Four Cures for Alcoholism," which has been used to treat alcoholism. According to the source book, a person who consumes this medicine, either with alcohol or water, is allegorically said to be able to awaken from the end of drunkenness and the desire to drink. Within the framework of the project implemented from 2015 to 2017, chemical, technological, and pharmacological studies were conducted on this prescription, resulting in the isolation and combination of biologically active substances to create Alcuremon tablets for the treatment of alcohol dependence and alcoholic hepatitis. Therefore, the need to conduct clinical studies to assess the feasibility and justification for incorporating Alcuremon tablets into therapeutic practice is the rationale for this study.

Aim: To study the effects of the traditional medicine Alcuremon on depression and anxiety in individuals with chronic alcoholism.

Materials and Methods: The study employed a clinical trial design combined with a descriptive research methodology, conducted at the Center for Addictology, Behavioral, and Psychological Assistance. A total of 50 individuals diagnosed with chronic alcoholism (ICD-10: F10.1 and F10.2), who met the inclusion criteria and provided informed consent, were enrolled in the study. Participants received two Alcuremon tablets of 0.5 g each, twice daily, morning and evening, for 30 days. The results of the study were analyzed using the Michigan Alcohol Dependence Assessment (MADA) test, administered to participants; the Zung Self-Rating Depression Scale (SDS) to assess the cause and level of depression; and the Hamilton Anxiety Rating Scale to measure anxiety, both before and after treatment, as well as 30 days following the treatment.

Results: In the study, participants diagnosed with chronic alcoholism were classified by diagnostic group: 60% (n=18) were diagnosed with ICD-10 F10.2, Alcohol Dependence, and 40% (n=12) were diagnosed with F10.1, Alcohol Abuse. The demographic characteristics of the study participants were as follows: Out of a total of 30 participants aged 30-68 years, 27 (90%) were male and 3 (10%) were female, with a median age of 49.56±10.36 years. In terms of education, 53.3% (n=16) had completed secondary education, while 46.7% (n=14) had higher education. Of those diagnosed with alcoholism, 76.7% (n=23) were smokers, while 23.3% (n=7) were non-smokers. The length of alcohol abuse ranged from 1 to 25 years, with a mean of 9.13±5.32 years. When assessing alcohol dependence using the MADA test, the mean alcohol dependence score before treatment was 33.40±1.72, indicating Stage III of alcoholic dependence. After treatment, the score decreased to 31.20±8.72, but no statistically significant difference was observed (P=0.068, t=1.86). Upon assessing the level of depression using the SDS test, the mean depression score was 45.03±9.92 before treatment, which decreased to 30.96±8.23 after treatment, showing a statistically significant difference (P=0.000, t=5.43). Using the Hamilton Anxiety Rating Scale, the mean anxiety score before treatment was 23.82±12.03, indicating severe anxiety. After treatment, it decreased to 9.00±8.43, reflecting moderate anxiety, with a statistically significant difference (P=0.0001, t=7.19). Upon assessing the relationship between factors affecting alcohol consumption in individuals with alcohol use disorders using Pearson's test (Burns and Grove, 2005), the following findings were observed: the age of onset of alcohol consumption was 21.06±5.66 years, the years of heavy drinking was 9.13±5.32, the alcohol dependence score was 33.40±9.72, the depression level was 45.03±9.92, and the anxiety level was 23.83±12.03, respectively.

Conclusion: The traditional medicine Alcuremon was found to be effective (P<0.05) in reducing depression and anxiety in individuals with alcoholism. Alcohol dependence was found to be positively and strongly correlated with depression (r=0.57) and anxiety disorders (r=0.66).

Keywords: Channadselshi, Hamilton, Zung Self-Rating Depression Scale, Alcoholism, traditional medicine